



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/40

Улаанбаатар хот

Нийслэлийн Байгаль орчны газрын  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 03 дугаар сарын 5-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 51,552,135.34 /тавин нэгэн сая таван зуун тавин хоёр мянга нэг зуун гучин таван төгрөг гучин дөрвөн мөнгө/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан 17 ширхэг минжийг байгальд нутагшуулж байгаатай холбогдуулан данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Байгаль орчны газар /М.Нямбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 51,552,135.34 /тавин нэгэн сая таван зуун тавин хоёр мянга нэг зуун гучин таван төгрөг гучин дөрвөн мөнгө/ төгрөгийн үнэ бүхий 17 ширхэг минжийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор байгальд нутагшуулж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Байгаль орчны газар /М.Нямбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/450 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА




М.БАЯРАА

Тушаал-2021

**115050000113**

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын  
даргын 2021 оны 03 дугаар сарын 16 өдрийн  
110 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Байгаль орчны газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил /нас/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	ЭБХХК-ын хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж							
1	Минж/ХБНГУ-эм/	4	ш	4	1,881,959	7,527,836.00	байгальд нутагшуулах
2	Минж	6	ш	1	1,887,085	1,887,085.00	байгальд нутагшуулах
3	Минж/ХБНГУ-эр/	5	ш	2	1,881,959	3,763,918.00	байгальд нутагшуулах
4	Минж/ХБНГУ-эр/	3	ш	3	1,881,959	5,645,877.00	байгальд нутагшуулах
5	Минж/ХБНГУ-эм/	4	ш	1	1,881,959	1,881,959.00	байгальд нутагшуулах
6	Минж/ОХУ-эр/	5	ш	1	6,900,695	6,900,695.00	байгальд нутагшуулах
7	Минж/ХБНГУ-эм/	4	ш	2	1,881,959	3,763,918.00	байгальд нутагшуулах
8	Минж/ОХУ-эм/	4	ш	2	6,900,695	13,801,390.00	байгальд нутагшуулах
9	Минж/ОХУ-эр/	4	ш	1	6,379,457.34	6,379,457.34	байгальд нутагшуулах
				17			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн						51,552,135.34	
Актлах хөрөнгийн дүн						<b>51,552,135.34</b>	